



ХОТ ТӨЛӨВЛӨЛТ, СУДАЛГААНЫ ИНСТИТУТ ОНӨААТҮГ ДАРГЫН ТУШААЛ

2022 оны 08 сарын 29 өдөр

Дугаар A/41

Улаанбаатар хот

Г Хяналтын камер ашиглах журам батлах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.10 дахь заалт, Хөдөлмөрийн тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.2.8 дахь заалт, “Хот төлөвлөлт, судалгааны институт” ОНӨААТҮГ-ын дүрмийн 6 дугаар зүйлийн 6.8.7 дахь заалт, Хот төлөвлөлт, судалгааны институт ОНӨААТҮГ-ын Хөдөлмөрийн дотоод журмыг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1. Институтийн ажилтнуудын ажлын цаг ашиглалтад хяналт тавих, аливаа төрлийн зөрчил дутагдлаас урьдчилан сэргийлэх, илэрсэн зөрчлийг таслан зогсоох, ажлын байрны эрүүл, аюулгүй орчинг бүрдүүлж, өдөр тутмын хэвийн тасралтгүй үйл ажиллагааг хангах зайлшгүй шаардлагаар ажлын байранд хяналтын тоног төхөөрөмж ажиллуулах, ашиглах журмыг нэгдүгээр хавсралтаар, хяналтын төхөөрөмжийн нэр төрөл, техникийн үзүүлэлтийг хоёрдуугаар хавсралтаар баталсугай.

2. Хяналтын төхөөрөмж худалдан авах, хяналтын камер суурилуулах, тохируулга хийх зардалд 5,954,850 (таван сая есөн зуун тавин дөрвөн мянга найман зуун тавь) төгрөгийг холбогдох хууль тогтоомжийн дагуу Институтийн 2022 оны үйл ажиллагааны бусад зардлаас гаргахыг Ерөнхий нягтлан бодогч (О.Бямбасүрэн)-д зөвшөөрсүгэй.

3. Хяналтын тоног төхөөрөмжийн өдөр тутмын ашиглалт, үйлчилгээ, найдвартай хэвийн ажиллагааг хариуцаж, тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Захиргаа менежментийн хэлтэс (Л.Эрдэнэбат)-д үүрэг болгосугай.

ДАРГА

С.ОЧИР-ЭРДЭНЭ



Хяналтын камер ашиглах журам

ТУ31925 9020010718 5369568

Нэг. Зорилго

- 1.1. Институтийн ажилтнуудын ажлын цаг ашиглалтад хяналт тавих, аливаа төрлийн зөрчил дутагдлаас урьдчилан сэргийлэх, илэрсэн зөрчлийг таслан зогсоох, ажлын байрны эрүүл, аюулгүй орчинг бурдүүлж, өдөр тутмын хэвийн тасралтгүй үйл ажиллагааг хангахад энэхүү журмын зорилго оршино.

Хоёр. Журмаар зохицуулах харилцаа

- 2.1. Институтийн ажлын ажлын байранд Хяналтын камер /цаашид “камер” гэх/ хяналт тавих, ашиглахтай холбоотой дараах харилцааг зохицуулна. Үүнд:
- 2.1.1 ажилтнуудаас байгууллагын байр, ажлын байранд албан харилцааны болон бусад зорилгоор нэвтэрсэн этгээдийн үйлдэл, үйл ажиллагаа байгууллагын ажилтнуудын эрх ашиг, эд хөрөнгөд хохирол учруулж болзошгүй эрсдэлийг хянах
- 2.1.2 ажилтнуудын цаг ашиглалт, ажлын гүйцэтгэл, аливаа үйлдэл, эс үйлдэхүй нь хууль тогтоомж, дотоод журамд нийцсэн эсэхийг хянах
- 2.1.3 системийн тасралтгүй найдвартай ажиллагааг хангахын тулд аливаа санаатай болон санамсаргүй үйлдсэн гэмт хэрэг, зөрчлийн шинжтэй үйлдэл, эс үйлдэхүйгээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, илэрсэн зөрчил, дутагдлыг хохирол багатай даван туулах, шаардлагатай бусад арга хэмжээг авах

Гурав. Хяналтын төхөөрөмжийн төрөл, байршил

- 3.1. Камер нь энэхүү журмын хавсралтад заасан нэр төрөл, техникийн үзүүлэлт, хангасан байх бөгөөд хуулиар хориглоогүй байршилд байрлуулна.
- 3.2. Хяналтын төхөөрөмж нь журмын хавсралтад заасан нэр төрлөөр хязгаарлагдахгүй, техникийн дэвшилтэт бусад төхөөрөмж, сайжруулсан загварыг ашиглаж болно.

Дөрөв. Төхөөрөмжийн ашиглалт үйлчилгээ

- 4.1. Хяналтын төхөөрөмжийн ашиглалт, үйлчилгээг Захиргаа менежментийн хэлтэс (ЗМХ) хариуцна.
- 4.2. ЗМХ нь хяналтын төхөөрөмжийн хэвийн ажиллагааг хариуцах бөгөөд техникийн тодорхойлолтыг нийлүүлэгчээс авч, түүнд заасан шаардлагатай засвар үйлчилгээ, программ хангамжийн хөгжүүлэлтийг тогтоосон хугацаанд хийж,

гүйцэтгэх, зайлшгүй тохиолдолд мэргэжлийн байгууллага, хувь хүнээр гүйцэтгүүлнэ.

- 4.3. ЗМХ нь ашиглалт, үйлчилгээтэй холбоотой зардлыг байгууллагын бизнес төлөвлөгөө, төсөвт суулган батлуулж, зарцуулалтыг холбогдох хууль, тогтоомжийн дагуу тайлагнана.

Тав. Хяналтын төхөөрөмжийн мэдээллийн сангийн ашиглалт, хандах эрх

- 5.1. Хяналтын төхөөрөмжийн мэдээллийн сан нь байгууллагын нууц мэдээлэлд хамаарах бөгөөд мэдээллийн сангийн ашиглалтыг байгууллагын нууцын журамд нийцүүлж гүйцэтгэнэ.
- 5.2. Дараах тохиолдолд хяналтын төхөөрөмжийн мэдээллийн сангаас дарга, түүний эзгүйд даргаас зөвшөөрөл олгосон албан тушаалтны зөвшөөрлөөр бусад ажилтан мэдээлэл ашиглаж болно. Үүнд:
 - 5.2.1 системийн хэвийн найдвартай ажилд сөргөөр нөлөөлж болзошгүй үйлдэл, эс үйлдэхүй илэрсэн
 - 5.2.2 ажлын байранд гэмт хэрэг, зөрчлийн шинжтэй үйлдэл тохиолдсон
 - 5.2.3 байгууллагын нэр хүнд, хэвийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөх бусад тохиолдол
- 5.3. Мэдээлэл авах хэлбэр, зорилго, үндэслэл нь хуульд нийцсэн тохиолдолд дараах байгууллагад мэдээллийн сангаас мэдээлэл ашиглуулж болно. Үүнд:
 - 5.3.1 Цагдаагийн байгууллага
 - 5.3.2 Авилгатай тэмцэх газар
 - 5.3.3 Тагнуулын ерөнхий газар
 - 5.3.4 Бусад хуулиар эрх олгогдсон байгууллага
- 5.4. Хүний хувийн мэдээллийг хамгаалах тухай хуулиар хамгаалсан мэдээллийг задруулахыг хориглоно.
- 5.5. Дүрсний бичлэгт мэдээллийн эznээс бусад хүний мэдээлэл байгаа тохиолдолд дүрсний бичлэгийг үзүүлэх, хуулбарлаж өгөхийг хориглоно.

Зургаа. Камерын байршил

- 6.1. Ариун цэврийн өрөө, хувцас солих өрөө зэрэг хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхэд илтэд халдахаар байршилд камер байршуулахыг хориглоно.
- 6.2. Камерын хяналтын мониторыг дараах байршилд байрлуулна.
 - 6.2.1 Ажлын өрөө, тасалгаанууд
 - 6.2.2 Хурал, уулзалт, хүлээлгийн өрөө

Долоо. Хариуцлага

- 7.1. Энэ журмыг зөрчсөн албан тушаалтны үйлдэл гэмт хэргийн шинжгүй бол Хөдөлмөрийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.
- 7.2. Энэ журмыг зөрчсөн хүнд Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.